



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/218

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 21 аймгийн дунд орон нутгийн багийн аварга шалгаруулах анхдугаар “Хөвсгөл цом-2022” шатрын тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Тэмцээнийг удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 06
дугаар сарын 27-ны өдрийн А/... ..
дугаар захирамжийн хавсралт

“ХӨВСГӨЛ ЦОМ -2022 “ШАТРЫН ТЭМЦЭЭН
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар- Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

П.Ариунбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч, аймгийн Шатрын холбооны гишүүн)

Ц.Мөнхсүлд (Аймгийн Шатрын холбооны нарийн бичгийн дарга,
тохиролцсноор)

Д.Сайнбаяр (Аймгийн Шатрын холбооны гишүүн, тохиролцсноор)

Г.Бямбасүрэн (Аймгийн Шатрын холбооны гишүүн, тохиролцсноор)

Б.Гантулга (Аймгийн Шатрын холбооны гишүүн, тохиролцсноор)

С.Мөнгөнтулга (Аймгийн Шатрын холбооны гишүүн, тохиролцсноор)

_____оОо_____